



**НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ**

**УЛС, ОРОН НУТГИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН**

**АУДИТЫН КОД: БУА-2021/60/-ШТА-НАА**

**ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДВАЛ ЗОХИХ ИРГЭД БҮРЭН  
ХАМРАГДАХГҮЙ БАЙНА.**

**БУЛГАН ХОТ 2020 ОН**

**Булган аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр  
Утас: 70342580**

**Аудитын менежер Ж.Энхцоодол  
Утас: 70342716**

**Ахлах аудитор Г.Намчинсүрэн  
Утас:70342716**

**Аудитор А.Сувдаа  
Утас:70342716**

**Аудитор З.Ганбаатар  
Утас:70342716**

**Энэхүү аудитын тайлантай холбоотой  
мэдээллийг дараах хаягаар авна уу.  
Цахим хуудас [www.audit.mn](http://www.audit.mn)**

## АГУУЛГА

---

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёог.....	4
Хавсралтын товъёог.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтийн талаарх шалгуур мэдэгдэл.....	5-9
БҮЛЭГ 1. Улс , орон нутгийн халамжийн сангийн хөрөнгийн төсвийн төслийг боловсруулахдаа нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд үндэслэн төлөвлөдөггүй байна.....	9-10
БҮЛЭГ 2. Улс, орон нутгийн халамжийн сангийн хөрөнгийг хууль журамд бүрэн нийцүүлэн зарцуулаагүй, Нийгмийн халамжийн сангийн зарим заалт, холбогдох бусад хууль, дүрэм журамтай уялдаагүй, бүртгэл мэдээллийн санг тухай бүр бүрэн шинэчилдэггүй байна.....	10-19
БҮЛЭГ 3. Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт тавих хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.....	19-20
БҮЛЭГ 4. Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.....	20-21
Байгууллагын саналд өгсөн тайлбар.....	21-22
Дүгнэлт.....	22-23
Зөвлөмж.....	23
Хавсралтууд.....	1-8
Байгууллагын санал.....	9-10

## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДЗ	Амьжиргааг дэмжих зөвлөл
БУА	Булган аймаг
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НАА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
НӨАТ	Нэмэн өртгийн албан татвар
НХҮ	Нийгмийн халамжийн үйлчилгээ
НХХ	Нийгмийн хөдөлмөр, хамгаалал
ОНОТ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн
УИХ	Улсын Их Хурал
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

## Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Халамжийн сангийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, иргэдэд олгосон мөнгөн дүн	8
Хүснэгт 2	Өрхийн мэдээллийн санд оруулсан өрхийн тоо	11
Хүснэгт 3	АДЗ-ийн гишүүдэд олгосон урамшууллын тооцоолол	15

## Хавсралтын товъёг

№	Тайлбар
Хавсралт 1	Улсын төсвийн халамжийн сангаас 2019-2020 оны зарцуулсан хөрөнгийн мэдээлэл
Хавсралт 2	Эрүүл мэндийн яамтай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн судалгаа
Хавсралт 3	АДЗ-ийн гишүүдэд олгосон урамшууллын тооцоолол /Дэлгэрэнгүй/
Хавсралт 4	Цахим хүсэлтээр олголт хийгдсэн иргэдийн судалгаа
Хавсралт 5	2020 онд нийгмийн халамжийн санд хамрагдсан иргэдийн мэдээлэл /Түүвэр/
Хавсралт 6	2020 онд нийгмийн халамжийн санд хамрагдсан иргэдийн мэдээлэл түүвэр /Дэлгэрэнгүй/

**Аудит хийх  
үндэслэл, бүрэн  
эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2020 оны 05 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2021 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

**Аудитын зорилт**

Улс, орон нутгийн халамжийн сангийн хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг аймгийн Засаг даргад танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтын хүрээнд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Улс, орон нутгийн халамжийн санг хууль, дүрэм журамд заасны дагуу төлөвлөж бүрдүүлсэн эсэх.
- Улс, орон нутгийн халамжийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх.
- Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт тавих хяналтыг хууль журамд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Тус аудитад аймаг, сум, ИТХ, ЗДТГ, болон тэдгээрийн харьяа холбогдох байгууллагууд, мэргэжилтэн, ХХҮГ, ХХҮГ-ын сумдын мэргэжилтнүүдийн 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамруулж, улсын болон орон нутгийн халамжийн сангийн хөрөнгийг төлөвлөлт, бүрдүүлэлт, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, хөгжлийн үйлчилгээг үзүүлэх холбогдох шийдвэр, зарцуулалт, анхан шатны баримт материал, хувийн хэргийг түүвэрлэн аудит хийлээ.

## Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан Нийцлийн аудитын түр журмыг баримтлан улс, орон нутгийн халамжийн сангийн 2020 оны үйл ажиллагаатай холбогдох шийдвэр, хувийн хэрэг, өрхийн мэдээллийн цахим систем, анхан шатны баримт материал, иргэдэд үзүүлсэн үйлчилгээ, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийг газар дээр нь очиж үзэх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, цуглуулсан ажлын баримт, тайлан, судалгааг харьцуулан дүгнэх, шаардлагатай ажлын баримтыг батлагдсан эрх зүйн баримт бичиг, төлбөрийн баримттай тулган баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд аудитын нарийвчилсан горим хэрэгжүүлж нэмэлт ажиллагаа хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Ахмад настны тухай
- Гэр бүлийн тухай
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай
- Хүүхдийн эрхийн тухай
- Хүүхэд хамгааллын тухай
- Хүүхэд харах үйлчилгээний тухай
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай
- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай
- Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай
- Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай
- Тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай /Нийгмийн халамжийн сангаас олгох зарим тэтгэмж, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн хэмжээ/
- Журам шинэчлэн батлах тухай. /“Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам”/
- Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /“Ахмад настанд үйлчилгээ

## **Аудитын бүрэлдэхүүн, хугацаа**

үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам"-ыг 1 дүгээр, "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг 2 дугаар, "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам"-ыг 3 дугаар, "Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санг удирдах, ашиглах журам"-ыг 4 дүгээр, "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг 5 дугаар хавсралт/

### **Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:**

Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2020 оны 05 дугаар сарын 03 -ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 05 дугаар сарын 31-ний өдрөөс тус тус эхлүүлэн гүйцэтгэж, аудитын нэгдсэн тайланг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт хүргүүллээ. /Аудитын үр өгөөжийн төлөвлөлтийг хавсралт 4<sup>4</sup>, нарийвчилсан цаглавар бүхий хөтөлбөрийг хавсралт<sup>1</sup> 5-д үзүүлэв/

### **Аудитыг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор А.Сувдаа, З.Ганбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

## **Хүндрэл бэрхшээл**

Аудитыг гүйцэтгэх явцад Covid-19 халдварт өвчний улмаас шалгагдагч байгууллагын мэргэжилтнүүдийн ХХҮЕГ-аас нэгдсэн журмаар гэнэт амраасан, шалгагдагч байгууллагын мэргэжилтэн, аудитыг гүйцэтгэж буй аудиторууд ээлж дараалан халдварт өвчнөөр өвдсөн, халдвар хамгааллыг дэглэмийг баримтлан тусгаарлалтад байсан, мөн 9 дүгээр сард тухайн аудитыг гүйцэтгэж буй аудиторууд нэгдсэн төлөвлөгөөтэй 2 аудитыг зэрэг гүйцэтгэсэн, шалгагдагч байгууллагаас аудитад шаардлагатай ирүүлсэн мэдээлэл алдаатай, дутуугаас нийт олголтын дүнд дахин тооцоолол, дүн шинжилгээг боловсруулсан зэрэг шалтгааны улмаас аудитыг баталсан хөтөлбөрийн дагуу гүйцэтгээгүй болно.

<sup>1</sup> Тайлбар: Тухайн хавсралтыг зөвхөн Төрийн аудитын байгууллагын дотоод хэрэгцээнд ашиглана.

## Ерөнхий мэдээлэл

Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг, аймаг, орон нутгийн зорилго, зорилт, хөтөлбөртэй уялдуулан нийт 12 зорилт, 58 арга хэмжээ тусгагдсанаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 13, нийгмийн халамжийн чиглэлээр 15, төрийн захиргааны чиглэлээр 30 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.

/Хүснэгт 1/

### ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ИРГЭД, ИРГЭДЭД ОЛГОСОН МӨНГӨН ДҮН

/төгрөгөөр/

№	Үйлчилгээний нэр	Шифр	Иргэдийн тоо	Олголтын тоо	Олголтын дүн
<b>УЛСЫН ТӨСӨВ</b>					
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	1000	1,243	12,433	3,059,230,660
2	Нийгмийн халамжийн тэтгэмж	2110-2113, 2120, 2130, 2140, 2141, 2213	1,792	18,399	1,571,269,300
3	Амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тэтгэмж	2213, 2214- 2215	1,686	7,289	843,718,830
4	Жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	2219, 2226	5,372	38,553	1,811,660,364
5	Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	2227	117	400	163,206,480
6	Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт тусламж	5000	2,617	2,655	338,933,750
7	ХБИ үзүүлсэн хөнгөлөлт тусламж	7000	569	938	97,214,730
8	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	6000	60	374	59,114,000
9	Алдарт эхийн 1,2 дугаар одонтой эхчүүдийн мөнгөн тусламж	2217-2218	5,756	5,759	739,200,000
10	65-аас дээш настай ахмадуудад насны хишиг	2403-2406	3,534	6,469	527,210,000
11	Ихэр хүүхдийн тэтгэмж	2211-2212	11	11	29,000,000
12	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	2401-2402	126	397	16,487,320
13	Хүнс тэжээлийн дэмжлэг	8301	4,494		1,041,528,000
Нийт /сангийн яамны олголт орсон дүн/			<b>23,005</b>	<b>93,800</b>	<b>9,269,405,434</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСӨВ</b>					
1	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	2221	8	8	9,600,000
2	Гэр оронгүй болсон өрх, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон өрх	2222	9	9	10,800,000
3	Хорих газраас суллагдсан гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэн	2224	3	3	3,600,000
4	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	2225	1	1	1,200,000
5	ОНОТХУ	3000	122	123	13,160,000
Нийт			<b>21</b>	<b>21</b>	<b>25,200,000</b>
<b>Бүгд/сангийн яамны олголт орсон дүн/</b>			<b>27,520</b>	<b>93,821</b>	<b>10,336,133,434</b>

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, халамжийн үйлчилгээ, хөгжлийн үйлчилгээг өмнөх он болон батлагдсан төсөвтэй харьцуулахад хамрагдсан хүний тоо 3.3 хувь, зарцуулсан мөнгөн дүн 13.5 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь Covid-19 цар тахалтай холбоотойгоор Засгийн газрын шийдвэрээр 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс халамжийн тэтгэвэр, хүүхдийн асаргааны тэтгэмж, хүнс тэжээлийн дэмжлэг олгох мөнгөн дүнг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, тусламжийн зардлыг 2016-2018 онуудад аймгийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байсан бол Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдаж улсын төсвөөс санхүүжилтийг олгосон байна.

Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоолоор “Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам”-ыг баталсны дагуу тухайн оны 09 дүгээр сараас эхлэн Насны хишиг, Жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, Ихэр хүүхдийн тэтгэмж, Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг цахим системээр олгож байгаа бөгөөд Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдэл, хөнгөлөлт хамрагдах иргэн цахим хэлбэрээр хүсэлт гаргах уг хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх ажил хийгдээгүй байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна Үүнд:

- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тус байгууллагын “Мэдээллийн самбар”-т байршуулан, тухай бүр шинэчсэн, байгууллагаас иргэд, олон нийтэд танилцуулах гарын авлага, зурагт хуудаснууд хэвлэн тараан байршуулсан, үүний зэрэгцээ байгууллагын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн телевизээр мэдээллийг хүргэсэн байна.
- Олон нийтийн сүлжээнд иргэдийг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын цахим сайт болон Facebook хуудсаар дамжуулан өдөр тутмын үйл ажиллагаа болон бусад мэдээ тайланг мэдээлсэн байна.
- Мөн аймгийн хэмжээнд нь байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор жил бүр нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байна.

## **Бүлэг 1**

***Улс , орон нутгийн халамжийн сангийн хөрөнгийн төсвийн төслийг боловсруулахдаа нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд үндэслэн төлөвлөдөггүй байна.***

### ***1.1. Улс, орон нутгийн халамжийн хөрөнгийг хууль, дүрэм, журамд бүрэн нийцүүлэн төлөвлөдөггүй байна.***

1.1. Төсвийн тухай хуульд заасны дагуу улс, орон нутгийн халамжийн сангийн дунд хугацааны төсвийн төслийг хуулийн хугацаанд төсвийн захирагчид хүргүүлдэг ч төсвийн төслийг боловсруулахдаа нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд үндэслэн төлөвлөдөггүй зөвхөн өмнөх хоёр оны

гүйцэтгэлийг үндэслэн тодорхой хувиар нэмэгдүүлэн төсвийн төслийн саналыг хүргүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/ Тухайлбал:

- Сумдын мэргэжилтнүүдэд орон нутгийн нийгмийн халамжийн санд хамрагдаж буй иргэдийн судалгаа дутмаг,
- Нийгмийн халамжийн санд хамрагдах боломжтой, эрсдэлтэй иргэдийн судалгааг хийдэггүй,
- Шилжилт хөдөлгөөнийг хуулийн хугацаанд хийдэггүй,
- Халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, халамжийн үйлчилгээ, халамжийн үйлчилгээний жилийн эцсийн мэдээний дүн нийт олголтын хаалтын дүнгээс зөрүүтэй,
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг сум, хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн тооцдоггүй бөгөөд сумдын амьжиргааг дэмжих зөвлөл идэвх санаачилгагүй ажилладаг,
- 2018-2020 оны орон нутгийн халамжийн сангийн хөрөнгийн батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулахад төсвийн гүйцэтгэл илүү, дутуу, /Хавсралт-1/
- Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хуульд заасан нэг удаагийн хөнгөлөлтийг төлөвлөхдөө иргэдийн тоонд квот тогтоодог зэрэг нь тооцооллыг үнэн, бодиттой тоон мэдээлэлд үндэслээгүй буюу Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1<sup>2</sup>-д заасантай нийцэхгүй байна.

1.2. Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8.17 -д заасан нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд дүн шинжилгээ хийж түүнд үндэслэн төсвийн төслийг боловсруулж байх зөвлөмжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүллээ.

## Бүлэг 2

*Улс, орон нутгийн халамжийн сангийн хөрөнгийг хууль журамд бүрэн нийцүүлэн зарцуулаагүй, Нийгмийн халамжийн сангийн зарим заалт, холбогдох бусад хууль, дүрэм журамтай уялдаагүй, бүртгэл мэдээллийн санг тухай бүр бүрэн шинэчлэгддэггүй байна.*

**2.1. Нийгмийн халамжийн бүртгэл мэдээллийн санг холбогдох хууль, журмын дагуу бүрэн шинэчлээгүй байна.**

2.1. Засгийн газрын 2013 онд баталсан “Улсын хэмжээнд судалгаа хийх тухай” 269 дүгээр тогтоолын дагуу Булган аймгийн статистикийн хэлтсээс нийт амьжиргааны түвшин тодорхойлох өрхийн тоо өгөгдсөний дагуу 2019 онд аймгийн нийт өрхийн 70.7 хувь буюу 13587, 2020 онд 72.7 хувь буюу 13914 өрхийг тус тус хамруулж мэдээллийн санд оруулсан байна.

*/Хүснэгт 2/*

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулсан өрхийн тоо

Д/д	Он	Аймгийн Статистикийн хэлтсээс гаргасан нийт өрхийн тоо	Мэдээллийн санд оруулсан өрхийн тоо	Асуулга авах өрхийн тоо	Нийт өрхөд эзлэх хувийн жин
1	2018	19072	11914	1154	62.5
2	2019	18481	13068	519	70.7
3	2020	18698	13587	327	72.7

<sup>2</sup> Санхүүжилтийг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээгээр тодорхойлсон байх;

2.2. Өрхийн амьжиргааны нөхцөл байдлыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Улсын бүртгэл статистикийн ерөнхий газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн А/64,А/460 тоот хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтын дагуу 3 бүлэгт үзүүлэлтээр судалж мэдээлэл цуглуулан олон улсад хэрэглэгддэг тооцооллын арга зүйг ашиглаж амьжиргааны түвшин тодорхойлдог байна.

2.3. Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллээр Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 20, 21, 22 дугаар зүйл заасан үйлчилгээнд зорилтот өрх, иргэнд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөх иргэн, төлбөрийн чадваргүй яллагдагчид үнэгүй өмгөөллийн үйлчилгээ, хорих ангиас суллагдсан иргэнд гэр олгох, хүүхдийн мөнгө үйлчилгээг үзүүлдэг байна.

2.4. Аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар нийт 18698<sup>3</sup> өрх бүртгэлтэйгээс өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй 4784<sup>4</sup> өрх байгаа нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг тодорхойлох, дээрх дурдсан халамжийн үйлчилгээнд хамрагдах нэн шаардлагатай өрхийг орхигдуулах эрсдэлтэй байна.

2.5. Мөн халамжийн нэгдсэн системд нас барсан, шилжин суурьшсан иргэдийн төлөвийг тухай бүр шинэчлээгүй байна.Тухайлбал: Баян-Агт сум нас барсан 1, Хутаг-Өндөр сум нас барсан 1, шилжин суурьшсан 1, Булган сум нас барсан 7 иргэний төлөвийг тус тус шинэчлээгүй байна.

***Цахим бүртгэлд халамжийн сангийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтийг хуулийн хугацаанд хянан баталгаажуулдаггүй, цахим хувийн хэргийн архивгүй байна.***

2.6. Иргэд олон нийтэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, цаг үетэй нийцүүлж цахим үйлчилгээ <https://ehalamj.mn/> -г тайлант онд нэвтрүүлжээ.

2.7. Уг цахим үйлчилгээнд олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах, өрх толгойлсон эцэг эх, насны хишиг, 2 ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэн үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй иргэд хаанаас ч цахимаар хүсэлтээ илгээж шийдвэрлүүлэх боломжтой ч дараах эрсдэлүүд үүсэж байна. Үүнд:

- Цахим хүсэлт ирүүлснээр үйлчилгээг үзүүлсэн нь Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журмын 6<sup>5</sup> дугаар зүйл, НББ-ын тухай хуулийн 13<sup>6</sup>-д заасны дагуу анхан шатны баримтын бүрдэлгүй,
- Ирүүлсэн иргэний хүсэлтийг мэргэжилтэн бүртгэл үүсгэснээр Ehalamj.mn цахим программд хүсэлт ирүүлсэн огноо харагдахгүй нь ЗГ-ын тогтоолд заасан хугацаанд тухайн иргэний хүсэлтийг шийдвэрлэдэг эсэх тодорхойгүй,
- ЗГ-ын 2020 оны 194 дүгээр тогтоолын дагуу цахим үйлчилгээг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор цахим архив үүсгэнэ гэж заасан ч одоогоор үүсгэсэн цахим архив байхгүй,

<sup>3</sup> Эх сурвалж Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

<sup>4</sup> Эх сурвалж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс

<sup>5</sup> Иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ;

<sup>6</sup> Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна

- АДЗ-ийн шийдвэргүйгээр цахим хүсэлтээр өрх толгойлсон эцэг, эрхийн тэтгэмжийн үйлчилгээ олгосон,
- Иргэдийн мэдлэг мэдээлэл дутмаг, малчин өрхийн иргэд интернэтийн сүлжээгүй орчинд ажиллаж, амьдарч байгаа зэргээс үйлчилгээнд мэргэжилтний тусламжтайгаар бүртгэл үүсгүүлж үйлчилгээнд хамрагдаж байна.

2.8. Иймд дээрх асуудлын хүрээнд шат шатны мэргэжилтнүүд дотоод хяналтаа сайжруулах, дээд шатны байгууллагад холбогдох саналыг хүргүүлэх, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

***Магадлан итгэмжлэгдээгүй дотоодын рашаан сувиллын үйлчилгээнд хамрагдсан иргэдэд халамжийн үйлчилгээг үзүүлсэн байна.***

2.9. Магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд 2020 онд нийт 249 хүндэт донор ахмад настан болон эмчилгээ сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд нийт 44408.0 мянган төгрөгийн үнийн хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

2.10. Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газраас ирүүлсэн магадлан итгэмжлэгдсэн 20 дотоод рашаан сувилал баталсан бөгөөд аймгийн хэмжээнд нийт 12 магадлан итгэмжилсэн рашаан сувилалд эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай рашаан сувиллаас үйлчилгээ авсан байна.

2.11. Зайлшгүй эмчилгээ, сувилгаа шаардлагатай ахмад настны илгээх бичигт дурдагдсан онош өмнө эмчилгээ, сувилгаа, оношилгоо хийлгэсэн эсэх бусад нотлох баримт байхгүй байна.

2.12. Энэ нь хөнгөлөлт эдлэх эрх үүсээгүй ахмад настанд хөнгөлөлт эдлэх, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах эрсдэлтэй байна.

2.13. Иймд дээрх зөрчлийг дахин давтахгүй байх, таслан зогсоох, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

***Протез, ортопед, болон тусгай хэрэгслийг гэрээ байгуулсан эрх бүхий байгууллагаас авсан боловч Ахмад настны тухай хуулийн 2.3 дахь заалт бүрэн хэрэгжихгүй байна.***

2.14. Ахмад настанд тусламж хөнгөлөлт үзүүлэх журмын 2.2<sup>7</sup>-д заасны дагуу ахмад настан шүдний протез, ортопедийн болон тусгай хэрэгслийг өөрийн сонгосон байгууллагаар хийлгэж болно гэж заасны дагуу 2020 онд 2905 ахмад настанд 293110.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг холбогдох шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн олгосон байна.

2.15. Ахмад настанд тусламж хөнгөлөлт үзүүлэх журмын 2.3-д<sup>8</sup>, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 9.1.6, 9.1.8-д зааснаар эрүүл мэндийн даатгалд хамаарах тусламж, үйлчилгээний багцад өртөг өндөр бүхий

<sup>7</sup>Ахмад настан шүдний протез, ортопедийн болон тусгай хэрэгслийг өөрийн сонгосон байгууллагаар хийлгэж болох бөгөөд энэ тохиолдолд энэхүү журмын 2.1- д заасны дагуу үнийг нөхөн олгоно. /Энэ заалтыг 2018-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

<sup>8</sup>Ахмад настан эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулсан байгууллагаар протез хийлгэсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас үнийг нөхөн олгоно.

зарим тусламж, үйлчилгээ, түүнд шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх зарим төрлийн хиймэл эрхтэн, протезийн зардлыг үнийн тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгохоор заасан ч 2020 онд Эрүүл мэндийн яамтай гэрээ байгуулсан 2 эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн 5 ахмад настны 32000.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг олгосон байна. /Хавсралт-2/

***Нийгмийн халамжийн үйлчилгээг нийлүүлж буй аж ахуй нэгж, байгууллагын тусгай зөвшөөрөлтэй эсэх нь тодорхойгүй байна.***

***Сумдын амьжиргаа дэмжих зөвлөлийг хууль, эрх зүйн сургалт, арга зүйн удирдлагаар хангах шаардлагатай байна.***

2.16. Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд “ ... амьжиргаа дэмжих зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байх ба сумын Засаг даргын санал болгосноор тухайн сумын ИТХ-аар хэлэлцэн батална” гэж заасан байна.

2.17. Үүний дагуу аймгийн 16 сум, 1 тосгонд 7 хүний бүрэлдэхүүнтэй Амьжиргаа дэмжих зөвлөл үйл ажиллагаа явуулж байна.

2.18. Амьжиргаа дэмжих зөвлөл нь Нийгмийн халамжийн тухай хуульд заасан тэтгэвэр тэтгэмж, халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй өрх, иргэдээс ирүүлсэн хүсэлт, судалгаанд үндэслэн баримт бичиг, амьдралын нөхцөлийг судлан, нийгмийн халамжийн холбогдох үйлчилгээнд хамрагдах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэх үндсэн үүрэгтэй байдаг байна.

2.19. Сумдын АДЗ-ийн хурлын тэмдэглэлээс харахад хүн ам цөөтэй сумдын зөвлөлийн гишүүд нь халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэн, өрхөө сайн мэддэг хэдий ч нөхцөл байдлын үнэлгээг хэрхэн хийж байгаа нь тодорхойгүй, зөвлөлийн гишүүд зарим айл, өрхөөр явж нөхцөл байдлын үнэлгээ хийж хэлэлцдэг гэсэн тайлбар өгч байгаа боловч холбогдох мэдээ, судалгаа, анхан шатны баримт байхгүй байна. Тухайлбал:

- Хутаг-Өндөр, Булган сумын асаргааны тэтгэмжид хамрагдах иргэдийг батлагдаагүй маягтаар амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр гаргасан,
- Зарим иргэдийг АДЗ-ийн шийдвэргүй халамжийн сангийн үйлчилгээнд хамруулсан,
- Цахим системд зарим үйлчилгээ нэвтэрсэнтэй холбоотойгоор цахим хүсэлтийн дагуу АДЗ-өөр хэлэлцүүлэлгүй халамжийн үйлчилгээнд шууд хамруулсан,
- АДЗ-ийн шийдвэргүйгээр тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг зогсоосон,
- АДЗ-ийн хэлэлцсэн асуудлаар хурлын тэмдэглэл хөтлөхгүйгээр шийдвэрийг гаргасан байна.

2.20. Дээр дурдсан зөрчил нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 28.8.3<sup>9</sup>, 28.8.9<sup>10</sup>, 28.9.1<sup>11</sup>, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм”-ийн 3.4<sup>12</sup>, 3.5<sup>13</sup>, 4.2.1<sup>14</sup>, 4.2.2<sup>15</sup>, 4.2.6<sup>16</sup>-д заасантай бүрэн нийцэхгүй байна.

2.21. АДЗ-ийн дүрэмд зөвлөлийн гишүүдэд улиралд нэг удаа урамшуулал олгоно гэж заасны дагуу аймгийн хэмжээнд 16954.5 мянган төгрөгийн урамшуулал олгожээ.

2.22. НХХ-ийн сайдын 2012 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Амьжиргаа дэмжих зөвлөлийн дүрэм”-ийн 5.4-т “... аймгийн нийгмийн халамжийн байгууллага нь АДЗ-ийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, зөвлөлийн гишүүдийг сургах, үйл ажиллагаатай нь танилцах ажлыг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

2.23. Байгууллагын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд АДЗ-ийн үйл ажиллагаанд сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх ажил тусгагдаагүй, хэрэгжүүлсэн тодорхой ажил байхгүй байна.

2.24. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/89 дүгээр тушаалаар амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүнд улиралд олгох нэг удаагийн урамшууллыг оролцоо, ирцэд үндэслэн олгох НХХС-ын 2012 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 1.6<sup>17</sup>-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.25. АДЗ-ийн дүрмийн 1.6-д заасан тайланд хурлын ирц, оролцоо, мөнгөн тусламжид хамрагдах өрх, иргэний амьдралын нөхцөлийг судлах ажилд биечлэн оролцсон байдал зэргийг тодорхой тусгах байтал зөвхөн ирц, хэлэлцсэн асуудлаас өөр тодорхой зүйл тусгаагүй, хурлын тэмдэглэлгүйгээр урамшууллыг тооцож олгосон, мөн түүнд тавих хяналт сулаас 1158.4 мянган төгрөгийн илүү урамшуулал олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлээ./Хавсралт-3/

---

<sup>9</sup> Тэтгэвэр тэтгэмж авах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлж, шийдвэрлүүлэх;

<sup>10</sup> Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, журам, зааврыг хэрэгжүүлэх;

<sup>11</sup> Нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх байгууллага, иргэнийг сонгоход оролцох, үйлчилгээнийх нь чанарт хяналт тавих, үнэлгээ хийх;

<sup>12</sup> Зөвлөлийн шийдвэр нь хурлын тэмдэглэлд тусгаагдах бөгөөд шийдвэрийн хэсгийг хуралдаанд оролцсон гишүүдийн гарын үсэг, тухайн сум, хорооны Засаг даргын тамгаар баталгаажуулна. Зөвлөл нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.7-д заасны дагуу хурлын шийдвэрийг нийтэд нээлттэй, ил тод байлгана;

<sup>13</sup> Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан гүйцэтгэх бөгөөд хуралд оруулах асуудлын бүрдлийг хариуцан хянаж бэлтгэнэ;

<sup>14</sup> Энэхүү дүрмийн 1.2-т заасан өрх, иргэний баримт бичиг, амьдралын нөхцөлийг судлан үзэж, хууль тогтоомжид заасан хугацаанд хэлэлцэж шийдвэрлэх, холбогдох байгууллагад шийдвэрийг хүргүүлэх;

<sup>15</sup> Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч холбогдох арга хэмжээ авах;

<sup>16</sup> Үйл ажиллагаагаа суманд Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, хороонд иргэдийн Нийтийн Хуралд жил тутам, сум, хорооны Засаг дарга болон аймаг, дүүргийн тайлагнах. Тайланд гишүүдийн хурлын ирц, оролцоо, энэхүү дүрмийн 1.2-т заасан өрх, иргэний амьдралын нөхцөлийг судлах ажилд биечлэн оролцсон байдал зэргийг тодорхой тусгах;

<sup>17</sup> Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэхүү дүрмийн 4.2.6-д заасан тайланг үндэслэн Зөвлөлийн гишүүн, сум, хороо /баг, тосгон/-ны нийгмийн ажилтанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.10-т заасны дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан хэмжээнд багтаан улиралд нэг удаа урамшуулал олгоно.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд олгосон урамшууллын тооцоолол

/мян.төг/

№	Сум / Дүүрэг	АДЗ-ийн шийдвэрийн тоо	Олгосон дүн	Олголтын тоо	Олговол зохих дүн	Зөрүү /- илүү, +дутуу/
1	Дашинчилэн сум	19	786.24	21	1033.92	-12
2	Бүрэг хангай сум	18	1123.2	27	869.04	-254
3	Орхон сум	14	1209.6	28	941.76	-268
4	Баян-Агт сум	11	921.6	17	936	14
5	Сайхан сум	22	1083.6	26	761	-323
6	Хутаг-Өндөр сум	13	1175.04	28	1175.04	0
7	Баяннуур сум	10	1094.4	28	993.6	-101
8	Булган сум	14	1152	27	950.4	-202
Нийт		121	8545.68	202	7660.5	-1144.4

2.26. Сумдын АДЗ-ийн гишүүд халамжийн үйлчилгээний талаарх мэдлэг арга зүй дутмаг, зөвлөлийн нарийн бичгийн даргаас ямар хуулийн заалттай байдаг, ямар арга хэмжээ авах зэргийг хурлын үеэр асууж шийдвэр гаргасан байна.

2.27. Аймаг, сумын хэмжээнд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд хамрагдах ХБИ-ийн судалгаанаас бусад өрх, иргэний тоо болон халамжийн хэрэгцээний судалгааг гаргах мэдээллийн сан бүрдүүлэх ажил хангалтгүй, сумдын халамжийн мэргэжилтнүүдийн ХБИ-ийн судалгаанд байхгүй иргэдэд халамжийг үйлчилгээ үзүүлсэн, сум орон нутгийн удирдлагыг үнэн зөв, бодиттой мэдээллээр бүрэн хангадаггүй, халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэд бүрэн хамрагддаггүй.

2.28. Иймд сумдын АЗД-д нийгмийн халамжийн үйл ажиллагаа, хууль эрх зүйн талаар сургалт, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, улирлын тайланг заасан хугацаанд ирүүлэхэд анхаарч, олгох урамшууллыг гишүүдийн оролцоонд үндэслэн тооцох нь зүйтэй байна.

***Нийгмийн халамжийн сангаас 8 иргэний 1,185.0 мянган төгрөгийн тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас давхардуулан олгосон байна.***

2.29. Нийгмийн халамжийн сангаас 2020 онд нийт 1142 хүнд 3,059,230.6 мянган төгрөгийн тэтгэврийг олгосон байна.

2.30. Аудитаар тэтгэвэр авсан 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй 124 иргэдийн нэрсийг нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн нэрстэй харьцуулж давхардал, илүү олголт байгаа эсэхэд тулгалт хийхэд 8 иргэний 1,185.8 мянган төгрөгийн илүү олголт байна.

2.31. Үүнээс 2020 онд хийгдсэн дотоод хяналт шалгалтаар 7 иргэний 1,155.0 мянган төгрөгийг төлүүлж 1 иргэний 30.2 мянган төгрөгийг давхардуулан олгосон зөрчил илэрсэн байна.

***Шалгуур үзүүлэлт, баримтын бүрдэл хангалтгүй иргэдийг халамжийн сангийн үйлчилгээнд хамруулсан байна.***

2.32. Халамжийн цахим үйлчилгээнд хамрагдсан нийт 1543 иргэнээс 246927.9 мянган төгрөгийн 76.1 хувь буюу 1175 иргэний анхан шатны баримт байхгүй, цахим архив үүсгээгүй нь ЗГ-ын 2020 оны 194 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн

халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам"-ын 3.5<sup>18</sup>-д заасантай нийцэхгүй байна. /хавсралт 4/

2.33. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд хамрагдсан иргэдээс цахим үйлчилгээнд /ehalamj.mn/ хамрагдсан иргэдээс бусад иргэдэд хувийн хэрэг үүсгэн халамжийн санд хамруулж байна. Иргэдийн ирүүлсэн баримт материалд дараах нийтлэг алдаа, илэрч байна. Үүнд:

- Иргэний иргэний үнэмлэхийн хугацаа дууссан,
- Багийн Засаг даргын тодорхойлолтын огноо дутуу,
- Асрагч, асруулагчийн хаяг өөр, хоёроос дээш асруулагчийн амьдарч буй хаяг өөр,
- Сунгалт хийлгэхдээ асрагчийн баримт материалыг авалгүй зөвхөн асруулагчийн комиссын шийдвэрийг үндэслэл болгодог,
- Гурвалсан гэрээг баталгаажуулдаггүй, сунгалт хийдэггүй, асрагчийн гарын үсэг өөр,
- Сумдын эрүүл мэндийн төвөөс асаргаанд хамрагдах шаардлагатай иргэдийг тодорхойлохдоо эрхлэгч эмч баталгаажуулсан байна.

2.34. Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 4.5<sup>19</sup>, 6.1<sup>20</sup>, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын 2012 оны 162 тоот тушаалын 3 дугаар хавсралт “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд асрах тухай гэрээ”-ний 2.3<sup>21</sup>, 5.1<sup>22</sup>, Эрүүл мэндийн сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/69/48 дугаар хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралтын 3.2<sup>23</sup>-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Холбогдох хууль, журмын дагуу халамжийн сангийн үйлчилгээг олгоогүй байна.***

2.35. Аудитын явцад ажилласан 8 суманд нийт 14572 иргэнд 6267.7 сая төгрөгийн олголт хийгдсэнээс нийт иргэдийн 13.5, нийт олгосон дүнгийн 4.4 хувийг холбогдох хууль, журмын дагуу олгоогүй байна. /Хавсралт-5/ Үүнд:

- Магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд эмчлүүлсэн ахмад настанд хөнгөлөлтийг олгохдоо энгийн өрөөний тарифаар тооцон олгоогүйгээс нийт 113.5 мянган төгрөгийн хөнгөлөлтийг илүү, 407.5 мянган төгрөгийг дутуу тооцож олгосон,
- Баян-Агт сумын бүрэн хараагүй иргэнд харилцаа холбооны зардал 30.0 дутуу олгосон,

<sup>18</sup> Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага цахим хэлбэрээр хүсэлт гарган нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэн тус бүрд цахим хувийн хэрэг үүсгэн архивлана;

<sup>19</sup> 4.5. Асаргааны тэтгэмжийг асруулагч тус бүрээр тооцож олгоно. Нэг иргэн нэг хаяг дээр оршин суугаа 3-аас дээшгүй иргэнийг асарч болно.

<sup>20</sup> 6.1. Иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ

<sup>21</sup> Гэрээг сумын ерөнхий эмч, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын комиссын шийдвэрт заасан хугацаагаар, ХХҮХ-ийн үнэлгээний дүн, гэрээг сунгах зөвшөөрөл, Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухай бүр сунгана;

<sup>22</sup> Энэхүү гэрээг сум, хорооны нийгмийн ажилтан, асрагч, асруулагч нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд энэ өдрөөс эхлэн гэрээгээр хүлээсэн тус тусын үүргээ хэрэгжүүлнэ;

<sup>23</sup> Өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийн дагуу өрх, төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд өвчтөний биеийн байдал, үзлэг, оношилгоо, шинжилгээгээр баталгаажсан онош, өвчний явц, үе шат, хүндрэл зэргийг тодорхойлон байнгын асаргаа тогтоох үндэслэлтэй бол комиссын хурлаар хэлэлцүүлнэ;

- Сайхан сумаас 2020 оны 8 дугаар сард шилжиж явсан 1 иргэнд 9, 10 дугаар сарын 64.0, нас барсан 1 иргэнд 64.0, Булган сум нас барсан 4 иргэнд 416.0 нийт 544.0 мянган төгрөгийн хүнсний хүнс тэжээлийн дэмжлэг олгосон,
- Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлэгдээгүй нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээг үзүүлж Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, мөн зөвлөлийн шийдвэрт шифр, регистрийн дугаар алдаатай тусгагдсан, тэтгэвэр тэтгэмж олгох журамд заасны дагуу өргөдөл өгсөн өдрөөр олголт хийгдээгүй нийт 68,547.4 мянган төгрөгийн олголтыг хийсэн,
- Бүрэгхангай сумаас 2020 оны 01 дүгээр сард өөр аймаг руу шилжсэн 2 иргэний нийт 7,205.0 мянган төгрөгийн тэтгэврийг олгосон,
- Орхон сумын 1 иргэнд нийгмийн халамжийн тэтгэврийг 103.8 төгрөгийг илүү тооцон олголт хийсэн,
- Цахим хүсэлт ирүүлснээс нийгмийн ажилтнаас ирүүлсэн 384 иргэний хүсэлтийг ажлын 5 хоногийн дотор хянан баталгаажуулаагүй нийт 99,725.0 мянган төгрөгийн олголтыг хийсэн,
- Хүнс тэжээлийн дэмжлэг авах үйлчилгээний шалгуур үзүүлэлтийг хангаагүй Баяннуур сумын хаягийн зөрчилтэй 2 өрх, 200 толгой малаас дээш малтай 1 өрх хасах, Хутаг-Өндөр суманд 5 өрх нь журмын дагуу олон нийт ажил, сургалт цуглаанд хамардаггүй иргэдэд дэмжлэгийг тус тус олгосон байна.

2.36.Энэ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1<sup>24</sup>, Ахмад настны тухай хуулийн 10.1.2<sup>25</sup>, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.6<sup>26</sup>, ЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоол “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 3.1<sup>27</sup> 4.11<sup>28</sup>,6.1<sup>29</sup>, 7.3<sup>30</sup>, 2017 оны 340 дүгээр тогтоол “Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журам”-ын 3.6<sup>31</sup>, 2017 оны 197 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам”-ын 3.9<sup>32</sup>, 2020 оны 194 дүгээр тогтоол “Нийгмийн халамжид хамрагдах

<sup>24</sup> Энэ хуулийн 3.1.2, 3.1.5, 18.2.4-т зааснаас бусад иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл/цаашид “Зөвлөл” гэх/ сум, хороонд ажиллана;

<sup>25</sup> эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох

<sup>26</sup> насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх

<sup>27</sup> Тэтгэвэр, тэтгэмжийг иргэний өргөдөл гаргасан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, нас барах, хуулиар тогтоосон бусад эрх нь дуусгавар болсны дараагийн сарыг дуусах хүртэлх хугацаанд олгоно;

<sup>28</sup> Иргэн байнга оршин сууж байсан засаг, захиргааны нэгжээс бүрмөсөн шилжсэнээс хойш 180 хоногийн дотор шилжин суурьшсан нутаг дэвсгэрийн захиргаанд бүртгүүлээгүй бол бүртгэлгүй байсан хугацааны тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн олгохгүй;

<sup>29</sup> Иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ;

<sup>30</sup> Сумын нийгмийн ажилтан, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан өрх, иргэний хувийн хэрэг, дэвтэрт тухай бүр бичилт хийж, хяналт тавьж ажиллана;

<sup>31</sup> Гурав болон түүнээс дээш хүүхэд төрүүлсэн өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1-д заасан Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр улирал бүр олгоно;

<sup>32</sup> Ахмад настны тухай хуулийн 10.1.2, 10.1.3, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 5.4.1, 5.4.2-т заасан хөнгөлөлт авах эрх бүхий ахмад настанд эрхийн бичгийн үнийг энгийн өрөөний тарифаар, тээврийн хэрэгслийн зардлыг авто замын болон агаарын тээврийн тарифт үнээр тооцож олгоно.

иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам”-ын 3.3<sup>33</sup>, 4.1<sup>34</sup>, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын 5.1.6<sup>35</sup>, 5.2.2<sup>36</sup>, 10.4<sup>37</sup> -д тус тус заасантай бүрэн нийцэхгүй байна. /хавсралт 6/

**Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаас бусад иргэнд тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ олгоогүй байна.**

2.37. Нийгмийн халамжийн тухай, ахмад настны тухай, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, алдар цолтой ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, ЗГ-аас баталсан холбогдох журамд зааснаас бусад иргэнд тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ үзүүлээгүй байна.

**Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа авсан иргэдийг холбогдох журамд заагдсанаас бусад хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан эсэхийг тодорхойлох боломжгүй байна.**

2.38. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2020 онд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээгээр 937 өрхөд 1,041,312.0 мянган төгрөгийн хүнсний эрхийг бичгийг олгожээ.

2.39. Аудитаар 591 өрхийн 626,744.0 мянган төгрөгийн хүнсний эрхийн бичгийн олголтыг түүвэрлэн тулгалт хийхэд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/32 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасан бүтээгдэхүүнээс бусад төрлийн бүтээгдэхүүн авсан эсэхийг тодорхойлох боломжгүй, учир нь хүнсний дэлгүүрүүдийн НӨАТ-ын баримтыг олгохдоо нэр төрлөөр гардаггүй, бөөн дүнгээр олгож байгаа нь хүнсний талоноор заагдаагүй бараа бүтээгдэхүүн авсан эсэхийг тодруулахад учир дутагдалтай байна.

2.40. Цаашид хүнсний дэлгүүрүүдтэй Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар баталсан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын 6 дугаар зүйлийн 6.10<sup>38</sup>, 6.11<sup>39</sup>-д заасан заалтуудтай бүрэн нийцүүлэн гэрээ байгуулан ажиллах шаардлагатай байна.

**Халамжийн тухай хуулийн 18.1.9-д заасан төсөл хэрэгжүүлсэн зарим өрх, бүлүүд нь үйл ажиллагаа явуулаагүй, төсөлд тусгасан асуудлыг бодит байдлаар хэрэгжүүлсэн баримт судалгаа, тайлан дутуу байна.**

2.41. Нийгмийн халамжийн тухай хуульд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд амьдрах ухаан, зөв дадал эзэмшүүлэх сургалтад

<sup>33</sup> Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага нь энэ журмын 2.1-д заасан системд хандан хүсэлт гаргасан иргэний цахим хүсэлт болон сум, хорооны нийгмийн ажилтнаас ирүүлсэн иргэний хүсэлтийг ажлын 5 хоногийн дотор хянан баталгаажуулна;

<sup>34</sup> Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдэл, хөнгөлөлтийг иргэнд цахим хэлбэрээр хүсэлт гаргасан өдрөөс эхлэн тооцож олгоно.

<sup>35</sup> Өрхийн гишүүн-иргэн нь хаягийн зөрчилтэй, өрх нь хаягтаа амьдрахгүй байгаа;

<sup>36</sup> Өрхийн гишүүн-иргэд аймаг, нийслэл хороонд шилжсэн бол

<sup>37</sup> Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэх;

<sup>38</sup> “Энэ журмын 6.5-д заасан аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүр нь энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хүнсний бараа бүтээгдэхүүнийг олон улсын стандарт GS1-13 зураасан кодоор бүртгэнэ”

<sup>39</sup> “Энэ журмын 6.5-д заасан аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүр нь НӨАТ-ын баримт, картын мэдээллийг нэгтгэн хэвлэдэг төхөөрөмжтэй байна”

хамруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэргээн засах, асрамжлан байрлуулах зэрэг 9 төрлийн үйлчилгээнд зорилтод иргэдийг хамруулахаар заажээ.

2.42. Аймгийн хэмжээнд Халамжийн тухай хуулийн 18.1-д заасан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнээс өдрийн үйлчилгээ, нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ гэсэн 3 төрлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

2.43. ОНОТ халамжийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор тогтмол үйл ажиллагаа явуулдаг 1 ТББ-тай өдрийн үйлчилгээ, гэрийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан нийт 122 иргэнд 13160.0 мянган төгрөгийг олгожээ.

2.44. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.9-д заасан үйлчилгээг хүргэхээр ХЭДС-гаас халамжийн үйлчилгээнд хамрагддаг нийт 50 хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настнуудыг шинэ ажлын байраар хангах зорилгоор 26040.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

2.46. Хэдийгээр нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах төслүүд нь зарим иргэдийг орлогын эх үүсвэртэй болгож байгаа боловч төслийг хэрэгжилтэд тавих хяналт сулаас дараах нийтлэг зөрчлүүд гарч байна. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлсэн зарим өрх, бүлүүд тусгасан үйл ажиллагаа явуулаагүй,
- Төсөлд тусгагдсан үйл ажиллагааг бодит байдлаар хэрэгжүүлсэн баримт, судалгаа, улирлын тайланг бүрэн хүргүүлдэггүй,
- Сумдын халамжийн мэргэжилтнүүдэд үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдлэг хандлага, зан үйлд төлөвшилд гарч байгаа өөрчлөлтүүдийн талаарх үнэлгээ, төсөл хэрэгжүүлснээр тухайн өрхийн орлого нэмэгдсэн талаарх судалгаа тайлан байхгүй байгаа нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны 07 дугаар сарын 18 өдрийн А/91 тоо тушаалын 2 дугаар хавсралтад заасан чанарын шалгуур үзүүлэлтийг хангаагүй, үр өгөөжөө өгөөгүй байна.

2.47. Иймд цаашид нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах төслүүдэд тавих хяналтыг сайжруулах, төсөл хэрэгжүүлснээр гарсан үр дүнг тооцох, үр өгөөжийг сайжруулах шаардлагатай байна.

### **Бүлэг 3**

***Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт тавих хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.***

**3.1. Хяналт, шинжилгээ үнэлгээний нэгжийн төлөвлөсөн зарим ажлууд хийгдээгүй байна.**

3.1. Нийгмийн халамжийн тухай хуулийн 24.8-д нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь НХҮ-ний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр тэтгэмжийн олголт, үйлчилгээний

чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина гэж заасан байна.

